



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 09 сарын 18 өдөр

Дугаар А/635

Булган сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 5.1.9, Ахмад настны тухай хуулийн 12.1, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны “Булган аймгийн 2024 оны төсөв баталсан тогтоолд өөрчлөлт оруулах тухай” 25/05 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 2020 оны II/04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Олон улсын ахмадын өдрийг тохиолдуулан зохион байгуулах арга хэмжээнд шаардагдах төсвийг хавсралтаар баталсугай.

2.Арга хэмжээ зохион байгуулахад шаардагдах 14,000,000 (арван дөрвөн сая) төгрөгийн 13,000,000 (арван гурван сая) төгрөгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны “Шинэ хөгжлийн зам” хөтөлбөр хэрэгжүүлэх зардлын Ахмад настны хөгжил хамгааллын төлөвлөгөөг хэрэгжүүлэх зардлаас, 1,000,000 (нэг сая) төгрөгийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус салбар зөвлөлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх зардлаас тус тус санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



6324010-70

Аймгийн Засаг даргын 2024 оны
09 дугаар сарын 18-ны өдрийн 1/63 дугаар
захирамжийн хавсралт

2024 ОНЫ ОЛОН УЛСЫН АХМАДЫН ӨДРИЙГ ТОХИОЛДУУЛАН
ЗОХИОН БАЙГУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨСӨВ

Д/д	Зардлын нэр	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1.	Булган сумын харьяалалгүй ахмад настнуудад хүндэтгэл үзүүлэх дархлаа дэмжих бүтээгдэхүүн	500ш	22,000	11,000,000
2.	"Аймгийн аварга - 2024" ахмадуудын Шагайн нумт харвааны тэмцээний шагналын зардал	2 тэмцээний нийт 7 шагналт байр		3,000,000
Нийт дүн				14,000,000